

МОНГОЛ, ХЯТАДЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабандийн урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Ху Жинтао 2003 оны зургадугаар сарын 4-5-нд Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Багабанди, Улсын дарга Ху Жинтао нар найрсаг байдалд хэлэлцээ хийв. Монгол Улсын Их Хурлын дарга С.Төмөр-Очир, Ерөнхий сайд Н.Энхбаяр нар Улсын дарга Ху Жинтао-д бараалхав. Хоёр улсын удирдагчид өөр өөрийн орны дотоод байдлын талаар харилцан мэдээлж, Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх болон олон улс, зарим бүс нутгийн өнөөгийн байдлын өргөн хүрээтэй асуудлаар нухацтай санал солилцож, нэгдмэл ойлголтод хүрэв. БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулганд үг хэлэв.

Найрсаг хөрш Монгол, Хятад хоёр улс 1994 оны Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ, 1998 оны Хамтарсан мэдэгдэл, 2002 оны Хамтарсан албан мэдээний үзэл санаа болон энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчимд тулгуурлан найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэх, мөнхийн сайн хөрш, сайн анд байх зорилгоор Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлэхээ санал нэгтэй мэдэгдэв.

Монгол, Хятадын харилцааг тогтвортой хөгжүүлэх, харилцан ойлгох явдлыг гүнзгийрүүлэхэд дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, уулзалт чухал ач холбогдолтой бөгөөд хоёр улсын удирдагч нар тогтмол уулзаж, харилцан айлчилж ирсэн уламжлалыг цаашид бататгах нь зүйтэй гэж хоёр тал тэмдэглэв.

БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагаа бүх талаар хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг мөн хэмээн Монголын тал нотлов. Монгол Улстай сайн хөршийн найрсаг харилцааг цаашид бататган хөгжүүлэх нь БНХАУ-аас хөрш зэргэлдээ орнуудтайгаа хэрэгжүүлж буй гадаад бодлогын чухал бүрэлдхүүн хэсэг мөн хэмээн Хятадын тал нотоллоо.

Талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, тус тусын сонгосон хөгжлийн замыг хүндэтгэхээ нотлов. Улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын асуудлаархи яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө байна. Хоёр улсын харилцааны аливаа

асуудлыг харилцан зөвлөлдөж зохицуулах, хамтран ажиллах замаар шийдвэрлэж байхын төлөө байгаагаа хоёр тал илэрхийлэв.

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус болон гадаадын цэрэг зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх Монгол Улсын чиг шугамыг хятадын тал дэмжиж байгаагаа илэрхийлэв. Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг, улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй, нөгөө талын төрийн бүрэн эрхт байдал, аюулгүй байдалд хохирол учруулах ямар нэгэн гэрээ хэлэлцээрийг гуравдагч оронтой байгуулахгүй гэдгээ дахин нотлов.

БНХАУ-ын Засгийн газар бол Хятад Улсыг төлөөлөх цорын ганц хууль ёсны Засгийн газар мөн, Тайвань бол Хятад Улсын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг бөгөөд Тайваний асуудал нь Хятадын дотоод хэрэг мөн гэж үздэгээ Монголын тал дахин нотлов. Монголын тал Тайваний асуудлаар Хятад Улсын явуулж буй “энх тайвнаар нэгтгэх”, “нэг улс хоёр систем”-ийн чиг бодлогыг дэмжиж, Тайвань тусгаар тогтнох гэгчийг дэмжихгүй гэдгээ илэрхийлэв.

Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд сүүлийн жилүүдэд ахиц гарсанд хоёр тал сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэв. Талууд харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, хамтын ажиллагааг олон салбар, сувгаар, төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлэхээр тохиролцов.

Хоёр тал худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцов. Талууд хоёр орны агаарын тээврийн шинэ замыг ойрын хугацаанд нээхээр тохиролцсон.

Аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэхээр хоёр тал тохиролцов. Хятадын Засгийн газар Монгол Улсыг “БНХАУ-ын иргэд өөрийн зардлаар жуулчлах орнуудын жагсаалтад” оруулах болсноо мэдэгдэв. Хоёр улсын байгаль орчныг хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах, соёл, боловсрол, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтын ажиллагаа, хүн солилцоог өргөжүүлэхээр болов.

Монгол, Хятадын хоёр улсын хилийн шугамыг хоёр дахь удаагаа хамтран шалгах ажлын явцад сэтгэл ханамжтай байгаа бөгөөд Монгол,

Хятадын хилийн шугамыг энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны зурвас болгох талаар санал нэгтэй байгаагаа талууд илэрхийлэв.

Айлчлалын үеэр талууд БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламж олгох тухай эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Хэлэлцээр, Улаанбаатар-Бээжингийн хооронд нэмэгдэл галт тэрэг аялуулах тухай Хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав. Монгол Улсын эдийн засгийн хөгжил, хоёр орны хамтын ажиллагааг Хятадын талаас дэмжиж хөнгөлттэй зээл, тусламж олгож ирсэн, энэ удаад мөн буцалтгүй тусламж олгож байгаад Монголын тал талархалаа илэрхийлэв.

Улс орнууд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм”-ийн зорилго, олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хүндэтгэж, аливаа улсын дотоод хэргийг тухайн улсын засгийн газар, ард түмэн өөрөө шийдэх ёстой. Олон улсын асуудлыг шийдвэрлэхэд улс орнууд тэгш эрхтэйгээр оролцох, олон улсын харилцаан дахь ардчиллыг хөхиүлэн дэмжих нь зүйтэй гэж талууд үзэв. Аливаа улс орны түүх, соёл иргэншил, нийгмийн байгуулал урт хугацааны туршид зэрэгцэн оршиж, хамтдаа хөгжих боломжтой гэж талууд санал нэгтэй үзсэн юм.

НҮБ нь засгийн газар хоорондын хамгийн нийтлэг шинжтэй олон улсын байгууллага мөн бөгөөд дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын маргааныг шийдвэрлэх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймд НҮБ-ын үүрэг ролийг цаашид улам бэхжүүлэх нь зүйтэй гэж хоёр тал үзсэн юм.

Хоёр тал олон улс, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх, харилцан ойлгох явдыг гүнзгийрүүлэх чиглэлээр хоёр болон олон талын хүрээнд хамтын ажиллагаагаа эрчимжүүлэхээр тохиролцлоо.

Талууд бүс нутагт улс төрийн яриа хэлэлцээг өрнүүлэн хөгжүүлж, итгэлцлийг бэхжүүлэхэд тус тусын зүгээс гаргаж буй хүчин чармайлтыг дэмжиж байгаа бөгөөд Зүүн хойд Азийн яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хоёр талаас дэвшүүлсэн санал, санаачилгыг харилцан талархан хүлээн авлаа.

Солонгосын хойгийн энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах зорилгоор хоёр тал Солонгосын хойг цөмийн зэвсэгтгүй байхыг дэмжиж, тус хойгийн цөмийн асуудлыг яриа хэлэлцээний замаар, эв зүйгээр зохицуулахын төлөө байна. Саяхан болсон БНХАУ-

АНУ-БНАСАУ-ын Бээжингийн хэлэлцээ нь Солонгосын хойгийн цөмийн асуудлыг эв зүйгээр зохицуулахад нааштай эхлэл болсныг талууд дурдаж, уг хэлэлцээг амжилттай явуулахад БНХАУ-ын зүгээс гаргасан хүчин чармайлтыг Монголын тал өндрөөр үнэлэв. Талууд энэхүү үйл явцыг цаашид үргэлжлүүлэхийн чухлыг тэмдэглэлээ.

Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа /АПЕК/-ны гишүүн болох, мөн Ази, Европын чуулга уулзалт /АСЕМ/-ын үйл явцад нэгдэн орох Монгол Улсын эрмэлзлийг БНХАУ дэмжиж байна.

Хоёр тал тус тусын орны нийгэм, эдийн засгийн бүтээн байгуулалтын ололт амжилтыг харилцан өндрөөр үнэлж, цаашид бие биийн үндэсний хөгжлийг бататгах хүчин чармайлтыг дэмжихээ илэрхийлсэн.

Амьсгалын цочмог халтай хам шинж өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэлээр ажиллаж буй мэргэжлийн байгууллагуудын хэлхээ холбоог бэхжүүлэх, харилцан мэдээлэл солилцох зэргээр шинэ зуунд хүн төрөлхтөнд тулгарч буй энэхүү сорилтыг даван туулахын тулд хамтран ажиллахаа илэрхийлэв.

Халуун дотноор хүлээн авсан Монгол Улсын Засгийн газар, ард түмэнд БНХАУ-ын дарга Ху Жинтао талархал илэрхийлж, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хорооны дарга У Бангуо, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэн Жябао нараас Монгол Улсын Их Хурлын дарга С.Төмөр-Очир, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр нарт илгээсэн халуун дотно мэндчилгээг уламжлав. БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийг тааламжтай цагтаа БНХАУ-д айлчлахыг урив. Ерөнхийлөгч урилгыг талархан хүлээн авлаа.

Улаанбаатар хот. 2003 оны 6 дугаар сарын 5-ны өдөр